

ЭРДЭНЭ РЕСУРС НЬ ХӨНДИЙ ДҮҮРЭГ ДЭХ МОЛИБДЕН-ЗЭСИЙН ЗУУН МОД ТӨСЛИЙН ХҮДЭРЖИЛТИЙГ ТЭЛЛЭЭ

Хэвлэлийн мэдээ

Нова Скошиа муж, Халифакс хот
2023.07.06

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци (TSX: ERD | MSE: ERDN) (“Эрдэнэ Ресурс” эсвэл “Компани”) нь Монгол Улсын баруун өмнөд бүсэд Баянхөндий алтны төслөөс зүүн зүгт 35 км-т, Хөндий Эрдсийн Дүүрэгт орших компанийн 100% эзэмшлийн молибден-зэсийн порфирийн Зуун Мод төсөлд гүйцэтгэсэн өрөмдлөгийн хөтөлбөрийн 12 цооногийн үр дүнг танилцуулахад таатай байна. (Зураг 1 болон 2-той танилцана уу.)

Тодруулга

Эрдэнэ Ресурсийн ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал Петер Акерли: “Ази тивд хөгжүүлэлт хийгдээгүй хамгийн том молибден-зэсийн ордуудын нэг Зуун Мод төсөл дээр хийсэн хайгуулын хүрээнд нөөцийг ихээхэн хэмжээгээр нэмэгдүүлэх боломж харагдаж байна. Өрөмдлөгийн цооногийн үр дүнд ордын төв хүдэржилт болон интервалуудыг тэлсэн нь дундажаас өндөр агуулгатай байв. Мөн, ордоос хойд зүгт 1.7 км зайд нөөцийн зэрэг бүхий хүдэржилт илэрсэн нь энэхүү томоохон молибден-зэсийн цогцолбор нь бүх чиглэлд нээлттэйг илтгэж байна.”

“Монгол Улсын молибденийн хамгийн том хэрэглэгч улстай зэргэлдээ орших байршил болон Зуун Мод төслийн бүс нутагт дэд бүтэц хурдацтай сайжрах нөхцөл бүрдсэн төсөл хөгжүүлэлтэд эерэг нөлөө үзүүлэх болно. Түүнээс гадна ногоон хөгжлийг дэмжих шилжилтэд чухал ач холбогдолтой молибден-зэсийн эрэлт өдөр тутам нэмэгдсээр байна” хэмээн онцлов

Зуун Мод өрөмдлөгийн хөтөлбөрийн үр дүнгүүд

2023 оны Зуун Мод төслийн хайгуулын хөтөлбөрийг голлох хоёр зорилтын хүрээнд гүйцэтгэсэн ба зорилтуудыг амжилттай биелүүлэв. Үүнд:

- 2011 онд PRMGlobal компанийн боловсруулсан NI 43-101 нөөцийн тайланд тодорхойлсон өндөр агуулга бүхий цөм тэлэхийг батлаж, ордын хязгаар хэсэгт хүдэржилтийг тэлэх;
- Зуун Мод молибден-зэсийн ордын хүдэржилтийг томоохон цар хүрээгээр тэлэх боломжийг судлахад оршиж байв.

Ордын төв хэсэгт (ZMD-131 цооног) өндөр агуулга бүхий хүдэржилт үргэлжилж буйг шалгах болон ордын төвийн бүсийн (ZMD-132-с 135 цооног) бодитой нөөцийн үргэлжлэлийг тэлэх зорилтын хүрээнд нийт 2476 тууш метрийн 5 цооног өрөмдсөн.

Түүнээс гадна, Зуун Мод порфирийн цогцолборын талбайд 1619 тууш метр өрөмдөв. Хайгуулын хөтөлбөрийн онцлох үр дүнгүүдийг Хүснэгт 1-т танилцуулав.

Хүснэгт 1 – Үр дүнгүүдийн хураангуй

Цооног #	м-ээс	м хүртэл	өргөн ⁽³⁾ (м)	% Cu	% Mo	MoEq% ⁽²⁾
ZMD-131	116	490	374	0.072	0.053	0.063
Үүнд	246	320	74	0.088	0.080	0.092
үүнд	252	280	28	0.121	0.140	0.157
Үүнд	444	472	28	0.099	0.081	0.095
ZMD-132	260	310	50	0.081	0.040	0.051
Үүнд	260	282	22	0.088	0.060	0.072
ZMD-133	48	70	22	0.044	0.041	0.047
Ба	130	150	20	0.038	0.042	0.047
Ба	222	284	62	0.055	0.043	0.051
Ба	324	492	168	0.041	0.044	0.050
Үүнд	366	416	50	0.046	0.061	0.069
Үүнд	396	416	20	0.053	0.081	0.091
ZMD-134	74	116	42	0.047	0.040	0.047
ZMD-135	190	376.7 ⁽¹⁾	186.7	0.065	0.060	0.069
Үүнд	254	274	20	0.070	0.085	0.095
Үүнд	308	328	20	0.080	0.081	0.092
үүнд	338	362	24	0.094	0.085	0.098
ZMD-139	240	252	12	0.035	0.067	0.072

(1) Цооногийн төгсгөл

(2) MoEq тооцоолохдоо молибден US\$20/фунт ба зэс US\$3.70/фунт тулгуурласан. Өнөөг хүртэл гүйцэтгэсэн металлургийн судалгаанд тулгуурлан зэсийн металл авалтыг 75%-иар тооцсон.

(3) Тайлагнасан интервал нь цооногт огтлогдсон зузаан болно. Нэмэлт хайгуул хийснээр бодит зузаан болон хүдэржилтийн анизотропыг тодорхойлох боломжтой

ZMD-131 цооногт 0.140% Мо ба 0.121% Си агуулсан 29 метрийн интервал (252-с 280 метр) багтаасан 0.080% Мо дундаж агуулга бүхий хэд хэдэн бүсийг (28-с 74 метрийн өргөн) огтолсон ба эдгээр бүсүүд нь дундаж агуулга 0.053% Мо ба 0.072% Си бүхий 374 метрт багтаж байна. Өндөр агуулга бүхий төв бүсэд молибденийн хүдэржилт үргэлжилж буйг харгалзан Компани нь илүү өндөр агуулга бүхий бүсүүдэд блок моделийг нарийвчлах, өрөмдлөг хоорондын зайг багасгах боломжийг судалж байна. Хавсаргасан зураглал болон хөндлөн зүсэлтээр ZMD-131 цооногийн орчимд илүү өндөр агуулга бүхий молибденийн хүдэржилт үргэлжилж буйг харуулав (Хөндлөн зүсэлт А, В буюу зураг 3 ба 4).

Зуун Модын бодитой нөөцийн бүсийн (ZMD-132-135 цооног) хязгаар дагуу өрөмдсөн дөрвөн цооног нь 40-187 метрийн зузаан (>0.04% Мо) нөөцийн зэрэглэлийн хүдэржилт огтолсон. Онцлох үр дүнд ордын баруун хойд хязгаарын дагуу ZMD-135 цооногт 0.08% Мо-с өндөр агуулга бүхий 20-24 метрийн зузаан хэд хэдэн интервал огтолсон нь 0.06% Мо дундаж агуулга бүхий 187 нэг метрийн интервалд багтаж байна. ZMD-133 цооногт газрын гадаргаас 50 метрээс эхлэн (46-551 метр хүртэл

0.032% Мо агуулга бүхий 505 метр) нийт гүний турш буюу 551 метрийн дийлэнхид хүдэржилт огтолсон бөгөөд үүнд 0.2% молибденийн агуулга бүхий 2 метр интервал багтаж байна.

Хайгуулын цооног болох молибденийн хүдрийн биетээс хойд зүгт 1.7 км-т өрөмдсөн ZMD-139 цооногт (одоогоор ZMD-135 цооногтоор тодорхойлогдож буй) их хэмжээний молибденийн хүдэржилт огтолсон нь (0.067% Мо бүхий 12 метр) Зуун Мод порфирийн цогцолборт нийтлэг тохиолддог порфирит гранодиорит агуулсан. Одоогоор Зуун Мод орд болон энэхүү цооногийн хооронд өрөмдлөг хийгдээгүй бөгөөд ирээдүйд томоохон талбайд эрдэсжилт нээх боломжийг бий болголоо. Геофизикийн эсэргүүцлийн өгөгдлөөр энэхүү хоёр цооногийн хооронд хүдэржилт үргэлжлэх боломжтойг мөн харуулсан (Хөндлөн зүсэлт C – Зураг 5).

Зуун Мод порфирийн цогцолборын хойд бүсэд өрөмдсөн хэд хэдэн хайгуулын цооногуудад (ZMD -140-142 цооног) аномаль зэсийн хүдэржилт (0.05% Cu-с дээш) илэрсэн. ZMD-140 цооногийг зэсийн нээлтийн бүсийн өмнөд талбайд өрөмдсөн бөгөөд 0.2%-ээс дээш зэсийн агуулга бүхий 2 метрийн интервал огтолж, 244 метрт зэсийн хүдэржилтээр (0.1% зэсээс дээш) төгссөн. Зуун Мод порфирийн цогцолборын хойд бүс нь филлийн болон калийн хувирал бүхий кварц монзонит, гранодиоритын интрузив бүхий хэдэн км-т тархсан зэсийн хүдэржилт бүхий томоохон талбайг агуулдаг. Хэд хэдэн зэсийн хүдэржилт бүхий бүсүүдийг өргөн зайтай өрөмдлөгийн үеэр огтолсон бөгөөд үүнд (ZMD-121 цооног) 1.3% зэсийн агуулга бүхий 34 метр ба 308-с 342 метрт 9.24 г/т мөнгөний агуулга бүхий интервал багтаж байна. Энэхүү талбай нь гүндээ болон андезит хучилт бүхий трендийн дагуу баруун өмнө зүгт нээлттэй. Зэсийн хүдэржсэн интервалууд нь хүдэржилтийн гүний эх үүсвэрийг илтгэдэг калиар хувирч, хүдэржсэн хэлтэрхий болон гидротермалиар хувирсан интрузив брекчээр тодорхойлогддог. (Хөндлөн зүсэлт D – Зураг 6)

Төв ордын бүсээс баруун зүгт 1 км-т зүүнээс баруун тийш 600 метр хамарсан талбайд гурван цооног өрөмдсөнд аномаль молибден, зэс ба мөнгөний утга илэрсэн. ZMD-137 цооногийн эцсийн 40 метрт молибденийн өссөн агуулгатай (0.01% Мо-с дээш) байгаагаас гадна цооногт мөнгөний бүс огтолсон (цооногийн 62 метрээс эхлэн 38.6 г/т мөнгөний агуулга бүхий 4 метр). ZMD-138 цооногт аномаль молибден ба зэс илэрсэн бөгөөд үүнд 144 метрийн гүнд 0.068% Мо бүхий 2 метр, газрын дөт гүнд зэсийн хүдэржилт (цооногийн 4 метрээс эхлэн 0.2% Cu) илэрсэн.

Зуун Мод молибден-зэсийн төслийн тухай

Зуун Мод молибден-зэсийн төсөл нь дэлхийн хамгийн том зэс, молибденийн хэрэглэгч, ган үйлдвэрлэгч улс болох БНХАУ-ын хилийн боомт (Шивээхүрэн) болон Монгол улсын томоохон уул уурхайн дүүргээс баруун хойд зүгт ойролцоогоор 180 км-т, Баянхонгор аймгийн нутагт оршдог. Компанийн 100% эзэмшлийн ашиглалтын тусгай зөвшөөрөл нь 6,041 га талбайг хамардаг бөгөөд 60 жилийн хугацаанд хүчинтэй (2011 онд авсан). Төсөл нь Эрдэнэ Ресурсийн Баян Хөндий алтны төслөөс зүүн зүгт 35 км-т оршдог.

Эрдэнэ Ресурс нь олон жилийн хайгуулын хөтөлбөрөөр Зуун Мод молибден-зэсийн ордын хязгаар ба хэд хэдэн зэс, молибденийн хэтийн төлөв бүхий талбайг тодорхойлсон нь 16 км радиус бүхий порфирийн цогцолборт багтдаг.

2011 онд Minarco-MineConsult (RPMGlobal) нь Зуун Мод ордыг агуулж буй порфирийн системийн 3 км талбайд NI 43-101 нөөцийн тооцооллыг боловсруулсан. Хүснэгт 2-т тайлагнасан нөөцийн тооцооллыг санал болгосон захын агуулга (0.04% Мо)-ын дагуу харуулав.

Хүснэгт 2. Зуун Мод Төслийн Нөөцийн Тооцоолол, 2011.06

Төрөл	Хэмжээ Mt	Cu %	Mo агуулсан металл Mlbs	Mo %	Cu агуулсан металл Mlbs
Баттай	40	0.064	57.0	0.056	49.5
Бодитой	178	0.070	273.7	0.057	224.0
Баттай&Бодитой	218	0.069	330.7	0.057	273.5
Боломжтой	138	0.065	197.7	0.052	157.7

Эх сурвалж: NI 43-101 Technical Report, Zuun Mod Porphyry Molybdenum-Copper Project, Minarco-MineConsult, June 2011

Монгол Улсын баруун өмнөд бүсийн дэд бүтцийн хөгжил

Монгол Улсын Засгийн газар нь ГШХО болон худалдааг нэмэгдүүлэх замаар Шинэ Сэргэлтийн Бодлогыг идэвхитэй хэрэгжүүлэхээр зорьж байна. Энэхүү санаачлагын хүрээнд Монгол Улсын Засгийн газар нь Шивээхүрэн, Гашуунсухайт болон Бичигт боомтуудын дэд бүтцийг сайжруулахаар төлөвлөсөн. 5 сарын 27-нд Өмнөговь аймгийн Гурван Тэс сум түүнтэй зэргэлдээ орших БНХАУ-ын Секе боомтод байршилтай Шивээхүрэн-Секе хил холболтын төмөр замын бүтээн байгуулалтыг эхлүүлсэн бөгөөд 2023 оны сүүлээр эцэслэгдэх төлөвлөгөөтэй байна. Энэхүү төсөл нь Монгол Улсын стандарт царигтай замын эхний угсралт юм. Дээрх боомт нь Эрдэнэ Ресурсийн Зуун Мод төслөөс дунджаар 180 км-т оршдог. Цаашид Монголын баруун тэнхлэгийн төмөр замын сүлжээ нь Шивээхүрэн боомтыг Шинэжинст сумтай холбох төлөвлөгөөтэй байгаа нь төмөр замын сүлжээг Зуун Мод төслөөс 30 км зайд ойртуулах чухал ач холбогдолтой.

Монгол Улсын Засгийн газар Ховд аймгийн Эрдэнэбүрэн суманд БНХАУ-ын хөрөнгө оруулагчидтай хамтран усан цахилгаан станц барихаар төлөвлөж буйг мэдээлсэн. Энэхүү төсөл нь Монгол Улсын баруун бүсийн эдийн засгийн хөгжлийг дэмжихээс гадна Зуун Мод төслийн сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр болох боломжтой.

2023 оны 6 сарын 27-нд Монгол Улс нь АНУ-тай Энэтхэг-Номхон далайн бүс нутагт чухал ач холбогдолтой ашигт малтмалын нийлүүлэлтийн сүлжээг хөгжүүлэх Харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан. Энэхүү санамж бичгийн хүрээнд АНУ нь хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжих зэргээр Монгол Улсын чухал ач холбогдолтой ашигт малтмалын салбарыг хөгжүүлэх зорилгуудыг тусгасан.

Молибденийн тухай

Молибденийг газрын тос, хийн хоолой, ногоон эрчим хүч рүү шилжиж буй шинэ технологиудад ашиглахаас гадна бат бэх, зэвэрдэггүй хайлшны бүрэлдэхүүн болдог тул зэвэрдэггүй ган, сайжруулсан хайлш зэргийг үйлдвэрлэхэд ашиглагддаг. Молибден нь хөнгөн, өндөр температур ба зэврэлтэд маш тэсвэртэй бөгөөд бат бөх, хатуу, гагнагдах чанарыг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

2022 онд дэлхийн молибденийн үйлдвэрлэл 578 сая фунт байсан бол хэрэглээ нь өмнөх оны 614 сая фунтээс 3%-иар өсөж, 631 сая фунт болсон. Сүүлийн 5 жилийн хугацаанд молибденийн нийлүүлэлт тогтвортой байсан ч томоохон уурхайнуудын үйлдвэрлэл буурч, шинэ төсөл ашиглалтад орох хугацаа хойшлон, урт хугацааны молибденийн уурхайнуудын агуулга буурч, хомсдол үүссэн нь 2023 оны эхээр молибденийн үнэ огцом өсөж бүх цаг үеийн дээд хэмжээнд хүрэх нөхцлийг бүрдүүлсэн. Одоогийн өсөлтийн түвшингээр ирэх гурван жилд молибденийн зах зээлд 50 сая фунтын хомсдол үүсэх төлөвтэй байна. Бүс нутгийн хэрэглээ (БНХАУ, Япон, БНСУ) дэлхийн нийт нийлүүлэлтийн 50-иас дээш хувийг эзэлдэг ба БНХАУ 2022 онд үйлдвэрлэлээ 12%-иар өсгөж, дэлхийн хамгийн том молибден үйлдвэрлэгч болсон. Гэсэн хэдий ч 2022 онд 20 сая фунтийн хомсдол үүсэн, эрэлтээ хангаж чадахгүй байна. (IMOA 03/04/23)

Молибден нь цэвэр эрчим хүч үйлдвэрлэх, хадгалах технологид ашиглагддаг тул сэргээгдэх болон уламжлалт эрчим хүчний салбарын эрэлт өндөр. Дэлхийн банкны "Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг хэрэгжүүлж буй арга хэмжээ: Цэвэр эрчим хүчний шилжилтэд эрдсийн ач холбогдол" тайланд молибденийг ирээдүйн бүх ногоон технологид (2020) шаардлагатай зургаан чухал ашигт малтмалын нэг гэж онцолсон бол Олон улсын эрчим хүчний агентлаг (2021) молибденийг ногоон эрчим хүчний шилжилтийн чухал ашигт малтмал хэмээн тодорхойлсон.

Компанийн тухай

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Монгол Улсад суурь болон үнэт металлын хайгуул, төсөл хөгжүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлдэг Канад Улсад бүртгэлтэй хайгуулын компани. Компани нь Монгол Улсын баруун урд бүсэд хайгуулын 1, ашиглалтын 3 тусгай зөвшөөрлийн хувийг эзэмшдэг бөгөөд эдгээр хайгуулын бүсэд хийсэн судалгааны үр дүнд Хөндий Эрдсийн Дүүргийг нээн илрүүлсэн. Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Торонто болон Монголын хөрөнгийн биржүүд дээр бүртгэлтэй. Компанийн тухай дэлгэрэнгүй мэдээлэлтэй Компанийн вебсайт www.erdene.com-оос танилцах боломжтой. Компанийн талаарх чухал мэдээллүүд нь зөвхөн Компанийн вебсайтаар дамжин хүрдэг тул хөрөнгө оруулагчид вебсайтаар дамжуулан бодит мэдээлэл авахыг зөвлөж байна.

Мэргэшсэн этгээд (геологич)

Петер Далтон (Peter Dalton) нь Компанийн ахлах геологич (P.Geo, Nova Scotia) бөгөөд NI 43-101-т заасан мэргэшсэн этгээд ба урьдчилсан ТЭЗҮ, АШЭЗТ-оос бусад техникийн мэдээлэл, Баян Хөндийн эрдсийн баялаг, нөөцөөс бусад мэдээ мэдээллийг Эрдэнэ Ресурсийн зүгээс хянан баталгаажуулсан болно. Бүх дээжийг Улаанбаатар хот дахь Эс Жи Эс ("SGS") лабораторид шинжлүүлсэн. Эс Жи Эс лабораторийн дотоод хяналт шалгалтаас гадна, Компани нь тусгай стандарт бэлдэц, хээрийн болон лабораторийн хуулбар, мөн хүдэржилтгүй бэлдцийг ашиглан дээжийн чанарын хяналт, баталгаажуулалт ("QA/QC")-ын протоколыг гүйцэтгэсэн. Бүх дээжид 66 элементийн Индукцын хос пласмт спектрометрийн арга (ICP-OES буюу Inductively coupled plasma optical emission spectroscopy) болон Индукцын хос пласмт масс спектрометрийн арга (ICP-MS буюу Inductively coupled plasma mass spectrometry) ашигласан.

Эрдэнийн дээжлэлтийн протокол нь 2 метрийн интервалтайгаар, хүдэржилтийн дараа үеийн чулуулаг болон хүдэржилтгүй боржинг алгасан, цооногийг бүтнээр нь хамарсан дээжлэлтээс бүрддэг. Дээжлэлтийн интервалыг чөмгөн дээжний гүний метр дээр үндэслэдэг ба геологийн хяналт эсвэл хүдэржилтээс хамаардаггүй болно. Бүх дээжийг чөмгөн дээжний гүний метр дээр үндэслэн алмазан хөрөөгөөр 2 тэнцүү хуваадаг. Хуваагдсан дээжийн талыг дээжний уутанд ялган авч дээжилдэг бөгөөд үлдсэн талыг нь дээжний хайрцагт үлдээн Компанийн Баянхөндий дэх хээрийн ангид аюулгүй байдлыг ханган хадгалдаг. Бүх дээжийг нэг багцандаа 30 дээж байхаар хуваарилдаг ба багц болгонд стандарт бэлдэц, хүдэржилтгүй бэлдэц, лабораторийн хуулбар болон хээрийн хуулбар дээж буюу дээжийг 4 хуваан, 2-ыг нь 2 тусад нь дээжлэн Улаанбаатар дахь Эс Жи Эс (“SGS”) лаборатори руу шууд тээвэрлэдэг. Тээвэрлэлтийг Эрдэнэ Ресурсийн ложистикийн гэрээт Монруд ХХК гүйцэтгэдэг.

Тайлагнасан интервал нь бодит зузаан бөгөөд өөрөөр хэлбэл цооногийн өргөн юм. Зуун Мод талбайн өрөмдлөгийн цооногуудыг 85 градусын уналаар өрөмдсөн. Бодит өргөнийг баталгаажуулахын тулд нэмэлт судалгаа хийх шаардлагатай. Интервалуудын тайлагнасан агуулга нь түүвэр интервалын уртад үндэслэсэн жигнэсэн дундаж үзүүлэлтүүд юм. Дээд хязгаарлалт хийгээгүй.

Урьдчилсан таамаглал

Зарим мэдээллүүд нь Үнэт цаасны хуулийн хүрээнд урьдчилсан таамаглалуудыг агуулсан болохыг үүгээр мэдэгдэж байна. Урьдчилсан таамаглал нь урьд болж байсан болон ирээдүйд болох бодит баримт биш ба зөвхөн ирээдүйн төлөвлөгөө, стратеги, төсөл, нөхцөл байдалд тулгуурласан үзэл баримтлал, магадлал болон таамаглал болно. Энэхүү таамаглалууд нь тодорхой үндэслэлд тулгуурласан боловч баталгаа биш юм. Компанийн үйл ажиллагаа нь олон хүчин зүйлээс шалтгаалах бөгөөд зарим хүчин зүйлс нь Компанийн хяналтаас давсан байх магадлалтай ирээдүйд учирч болох хүчин зүйлс юм. Материаллаг өөрчлөлт үзүүлэх боломжтой хүчин зүйлсэд эрдсийн зах зээлийн үнэ, хайгуулын үр дүнгүүд, бизнесийн болон зах зээлийн орчин, эдийн засгийн байдал болон санхүүжилт, хөрөнгө босголт зэрэг орно. Дээр дурдсан мэдээллүүд нь ирээдүйд өөрчлөгдөн хувирах магадлалтай. Компани нь Үнэт цаасны хуульд өөрөөр заагаагүй тохиолдолд Урьдчилсан таамаглалыг өөрчлөн, шинэчлэх үүрэг хүлээхгүй.

Энэхүү хэвлэлийн мэдээ нь англи хэл дээр бэлтгэгдсэн хэвлэлийн мэдээний орчуулга болно. Англи, монгол хувилбаруудын хооронд зөрүү эсвэл зөрчилдөх зүйл гарвал англи хэл дээрх хувийг мөрдөнө.

ЭНЭХҮҮ МЭДЭЭЛЛИЙГ ОЛОН НИЙТЭД ТАНИЛЦУУЛАХАД ЯМАРВАА НЭГЭН ЗАСАГ ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА ЗӨВШӨӨРСӨН, ҮЛ ЗӨВШӨӨРСӨН МЭДЭГДЭЛ ХИЙГЭЭГҮЙ.

Холбоо барих:

Петер К. Акерли, Ерөнхийлөгч болон гүйцэтгэх захирал
Роберт Женкинс, Санхүү хариуцсан захирал

Утас: (902) 423-6419

И-мэйл: info@erdene.com


Twitter: <https://twitter.com/ErdeneRes>

Facebook: <https://www.facebook.com/ErdeneResource>

LinkedIn: <https://www.linkedin.com/company/erdene-resource-development-corp-/>


THE KHUNDII MINERALS DISTRICT – MOLYBDENUM-COPPER PROJECT

Molybdenum Copper Deposit, Four Gold Discoveries, and Multiple High-Priority Targets



ZUUN MOD PORPHYRY MO-CU PROJECT PLAN MAP

Molybdenum Soil Anomaly & Q2 2023 Drill Plan Map



ZMD-131: 277.6m
(0.83% Mo & 0.15% Cu(2m))

ZMD-131: 338.8m
(0.10% Mo & 0.06% Cu(2m))



43-101 Resource Estimate Cutoff 0.04% Mo

Ordinary Kriging Estimate Zuun Mod

NI 43-101 Classification	Tonnage Mt	Mo %	Mo lbs (000's)	Cu %	Cu lbs (000's)	Re PPM	Re lbs (000's)
Measured	40	0.056	49,500	0.064	57,000	0.225	20
Indicated	178	0.057	224,000	0.070	273,700	0.242	95
Total M&I	218	0.057	273,500	0.069	330,700	0.239	115


1 km

1cm

1cm

MOLYBDENUM RESOURCE CONTINUITY & EXPANSION UNDERCOVER

Zuun Mod Section A – Looking North



ZMD-132
50m avg. 0.05% MoEq
Incl. 22 m of 0.072% MoEq

← OPEN

Extension of High-Grade Molybdenum Undercover to West

Cu:Mo Ratio Increasing with depth

ZMD-131
374m avg. 0.067% MoEq
Incl. 28m avg. 0.157% MoEq

ZMD-131
28m avg. 0.095% MoEq
Extending High-Grade Resource at Depth

→ OPEN

- New Collar
- Previous Collar

GRADE SHELL MO

- ≥0.03%
- ≥0.06%
- ≥0.08%

200m

200m


400m

600m

MoEq (Molybdenum Equivalent) grades calculation is based on US\$3.70/lb Cu and US\$20/lb Mo. A recovery factor of 75% Cu was used for MoEq values.

STEP-OUT EXTENSION AND CONTINUITY OF HIGH-GRADE MOLYBDENUM


Zuun Mod Section B – Looking East




MoEq (Molybdenum Equivalent) grades calculation is based on US\$3.70/lb Cu and US\$20/lb Mo. A recovery factor of 75% Cu was used for MoEq values.

INTERSECTION OF PORPHYRITIC GRANODIORITE HOSTING RESOURCE-GRADE MOLYBDENUM 1.7KM FROM CURRENT ZUUN MOD RESOURCE


Zuun Mod Section C – Looking Northeast



ZMD-139
NEW Blind Top
Molybdenum Discovery



1.7km UNTESTED



ZMD-139
 12m avg. 0.072% MoEq
 Incl. grades up to 0.170 % Mo

1.7 km UNTESTED
IP Resistivity Signature Potentially Buried Intrusive Complex


OPEN

IP Resistivity Signature
 (>490ohm)

Maximum Vertical Extent of Current IP

NORTHERN ZUUN MOD COPPER ZONE – POTENTIAL EXPANSION OPPORTUNITIES

Zuun Mod North Section D – Looking North



ZMD-140: Targeted untested southern portion of copper zone in northern ZM; Hydrothermal breccia's with strongly silicified granodiorite fragments with quartz pyrite veins and anomalous copper exceeding 0.2% copper over 4 metres.

